ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ
/2021 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР/

2022.01.05 Улаанбаатар хот

| Д/д | Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт | № | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр | Зорилтот түвшин, үр дүн | | Хэрэгжилт хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2021 он | | |
| | | | | | | Зорилтот түвшин үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин үр дүн | |
| **ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО** | | | | | | | | |
| 2.1. Эрүүл мэнд. Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг өргөжүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна. | | | | | | | | |
| 1. | 2.1.3.Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан иргэд эх орондоо оношлогдон, эмчлүүлэх боломжийг нэмэгдүүлж, орчин үеийн үндэсний оношилгоо, эмчилгээний төвүүдийг шинээр байгуулна: | 11 | Захиалгын дагуу барилга байгууламжийн нэг маягийн болон давтан хэрэглэх зураг төсөл боловсруулах ажлыг зохион байгуулна. | 2020-2024 | - | Нэг маягийн зураг давтан хэрэглэх зураг төслийг боловсруулж батлуулсан байна. | 2021 онд 2 байршилд эмчилгээ, оношилгооны төвийн барилгын архитектур төлөвлөлтийн даалгавар, загвар зураг /нэг маягийн зураг давтан хэрэглэх зураг төсөл/ батлагдсан. Үүнд:<br>- БЗД-ийн 14-р хороо, Вакцин Био бэлдмэлийн агуулах /Улс, нийслэлийн хөрөнгө оруулалтаар/<br>- СХД-ийн 20-р хороо ЭМЯ, ЗӨСҮТ-ийн Эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн байр /Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр/. | 100 |
| 2. | 2.1.12. Аймаг, сумын эрүүл мэндийн байгууллага, эмнэлгүүдийн барилга байгууламж, дэд бүтцийг сайжруулан стандарт, чанарын шаардлага хангасан тэгш хүртээмжтэй, чанартай үйлчилгээг үзүүлэх орчныг бүрдүүлнэ. | 4 | Сум, өрхийн эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлгийн барилга байгууламж, дэд бүтцийн стандарт боловсруулж, хэрэгжүүлнэ. | 2022-2024 | - | Шаардлага хангасан байгууллагын тоо 75 болсон байна. | Хугацаа болоогүй | - |
| | | 6 | Захиалгын дагуу барилга байгууламжийн нэг маягийн болон | 2020-2024 | - | Нэг маягийн зураг давтан хэрэглэх зураг төслийг | - 2021 онд 7 байршилд Улс, нийслэлийн хөрөнгө оруулалтаар хийгдэх эрүүл мэндийн төв, эмнэлгийн барилгын Архитектур | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | давтан хэрэглэх зураг төсөл боловсруулах ажлыг зохион байгуулна. | | | боловсруулж батлуулсан байна. | төлөвлөлтийн даалгавар, загвар зураг батлагдсан. Үүнд:<br>✓ Хан-Уул дүүргийн 14-р хороо, Өрхийн эрүүл мэндийн төвийн барилга,<br>✓ Хан-Уул дүүргийн 04-р хороо, Нэгдсэн Эмнэлгийн барилгын өргөтгөл,<br>✓ Баянзүрх дүүргийн 05-р хороо, Нийгмийн Эрүүл мэндийн төвийн барилга,<br>✓ Эрүүл мэндийн яам, Халдварт өвчин судлалын үндэсний төвөөс Баянзүрх дүүргийн 14 дүгээр хороо, хүчилтөрөгчийн станцын барилга,<br>✓ Сүхбаатар дүүргийн 13 дугаар хороо, Нэгдсэн эмнэлгийн барилга,<br>✓ Багануур дүүргийн 5 дугаар хороо, Өрхийн эрүүл мэндийн төвийн барилга<br>✓ Чингэлтэй дүүргийн 4 дүгээр хороо, Эрүүл мэндийн төвийн барилгын загвар зураг тус тус батлагдсан.<br>- Эрүүл мэндийн яам, Нийслэлийн Эрүүл мэндийн газарт Эрүүл мэндийг дэмжих нийгмийн дэд бүтцийг нэмэгдүүлэх дээрх хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулахад хот төлөвлөлт, хот байгуулалтын чиглэлээр тулгамдаж байгаа асуудлаар санал иргүүлэн хамтран ажиллах 2021 оны 03/1631 дугаартай албан бичиг хүргүүлэв.<br>- Эрүүл мэндийн төв, Эмнэлгийн зориулалттай 7 барилгад Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээ олгосон. | |
| 3. | 2.1.14. Нүхэн жорлонтой эмнэлгийг үе шаттайгаар орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болгоно. | 2 | Сумдын эмнэлгийн ариун цэврийн байгууламжийг сайжруулах зураг төсөл боловсруулахад дэмжлэг үзүүлнэ. | 2020-2024 | - | Зураг төсөл боловсруулах ажлын даалгаврыг боловсруулж батлуулсан байна. | Нийслэлийн хэмжээний Зураг төсөл боловсруулах ажлын даалгаврыг баталдаг.<br>Хасах саналтай. | - |
| 2.2. Биеийн тамир, спорт. Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгож, мэргэжлийн спортыг дэмжиж, тамирчдын тив, дэлхий, олимпын түвшинд өрсөлдөх чадвар, амжилтыг нэмэгдүүлнэ. | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4. | 2.2.3.Иргэдэд үйлчлэх спортын зориулалтын стандарт талбайн хүртээмжийг нэмэгдүүлж, олон улсын жишигт нийцсэн спортын барилга байгууламжийг барина. | 8 | Захиалгын дагуу барилга байгууламжийн нэг маягийн болон давтан хэрэглэх зураг төсөл боловсруулах ажлыг зохион байгуулна. | 2020-2024 | - | Зураг төсөл боловсруулах ажлын даалгаврыг боловсруулах батлуулсан байна. | - 2021 онд 4 байршилд Улс, нийслэлийн хөрөнгө оруулалтаар хийгдэх спортын зориулалттай барилгын Архитектур төлөвлөлтийн даалгавар, загвар зураг батлагдсан. Үүнд:<br>✓ Сүхбаатар дүүргийн 19-р хорооны нутаг дэвсгэрт Спорт цогцолборын барилга,<br>✓ Сонгинохайрхан дүүргийн 03-р хороо, Засаг даргын Тамгын газар, Хөл бөмбөгийн талбай,<br>✓ Хан-Уул дүүргийн 08-р хороо, дүүргийн Засаг даргын Тамгын газар Спорт цогцолборын барилга,<br>✓ Баянзүрх дүүргийн 26-р хороо, Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн эдэлбэр газарт бэйсбол, регбигийн талбайн тохижилт<br>- Иргэн, хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтаар 2 байршилд спорт цогцолборын Архитектур төлөвлөлтийн даалгавар, загвар зураг батлагдсан. Үүнд:<br>✓ Баянзүрх дүүргийн 25-р хороо,<br>✓ 16-р хорооны нутаг дэвсгэрт<br>- Спортын зориулалттай 11 барилгад Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээ олгосон. | 100 |
| 2.3. Боловсрол. Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцоог бэхжүүлнэ. | | | | | | | | |
| 5. | 2.3.9.Суралцагчдад ээлтэй сургалтын орчныг бүрдүүлж, хүртээмжийг нэмэгдүүлэх, тусгай хэрэгцээт хүүхдийг ердийн сургууль, цэцэрлэгт сурах, хөгжих боломжийг нэмэгдүүлэх зорилгоор дараах бүтээн байгуулалтыг хийнэ.<br>Үүнд: | 7 | Барилга байгууламжийн нэг маягийн болон давтан хэрэглэх зураг төсөл боловсруулах ажлыг зохион байгуулна. | 2020-2024 | - | Захиалгын дагуу нэг маягийн зураг, давтан хэрэглэх зураг төслийг боловсруулах ажлыг зохион байгуулна. | 2021 онд 30 байршилд сургууль, цэцэрлэгийн барилгын архитектур төлөвлөлтийн даалгавар, загвар зураг баталсан. Үүнд:<br>*Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар*<br>- Сонгинохайрхан дүүрэг:<br>34-р хороо, 150 ортой цэцэрлэгийн барилга, 18-р хороо Ерөнхий боловсролын 12-р сургуулийн барилга, 31-р хороо, 176-р цэцэрлэгийн өргөтгөлийн барилга, 24-р хороо, Бага сургууль цэцэрлэгийн барилга,<br>- Чингэлтэй дүүрэг: | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 273 цэцэрлэг ашиглалтад оруулах,<br>200 шинэ сургууль ашиглалтад оруулах,<br>Тусгай хэрэгцээт сургууль, цэцэрлэгийн барилгыг шинэчилж, өргөтгөх,<br>Жил бүр нүхэн жорлонтой 100-аас доошгүй цэцэрлэг, сургууль, дотуур байрыг орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болгох. | | | | | | 06-р хороо, 50 дугаар сургуулийн зүүн урд талд 108-р цэцэрлэгийн барилга, 06-р хороо, орон сууцны 45 дугаар байрны баруун талд 74 дүгээр цэцэрлэгийн барилга, 8-р хороо, Сургуулийн барилга,<br>- Баянзүрх дүрэг:<br>04-р хороо, 97 дугаар сургуулийн барилга, 5-р хороо, 71-р цэцэрлэгийн өргөтгөлийн барилга , 18-р хороо, 84 дүгээр сургуулийн өргөтгөлийн барилга, 24-р хороо "Да хүрээ" худалдааны төвийн хойд талд цэцэрлэгийн барилга,<br>- Хан-Уул дүүрэг:<br>1-р хороо, Ерөнхий боловсролын 52-р сургуулийн хүзүүвчийн барилга, 4-р хороо, Номин супермаркетын зүүн талд цэцэрлэгийн барилга, 11-р хороо "Грандмед" эмнэлгийн зүүн талд сургуулийн барилга, 15-р хороо Төв цэнгэлдэх, хүрээлэнгийн зүүн талд цэцэрлэгийн барилга, 16-р хороо "Буянт-Ухаа 1" хорооллын зүүн талд цэцэрлэгийн барилга, 1-р хороо 67 дугаар цэцэрлэгийн хашаанд 67 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн барилга,<br>- Баянгол дүүрэг:<br>23-р хороонд Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор барилга.<br>*Иргэн, аж ахуй нэгжийн хөрөнгө оруулалтаар хийгдэх*<br>- Сонгинохайрхан дүүрэг 7-р хороо, Үйлчилгээтэй орон сууц, цэцэрлэгийн барилга,<br>- Баянгол дүүрэг 11-р хороо, Их сургуулийн хичээлийн байр, дотуур байрны барилга,<br>- Баянзүрх дүүргийн 8-р хороо, Орон сууц, цэцэрлэгийн барилга<br>- Хан-Уул дүүргийн 21-р хорооны нутаг дэвсгэрт "Буянт-Ухаа" спорт цогцолборын урд талд сургууль, цэцэрлэгийн барилга. | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 2021 онд 17 сургууль, сургуулийн цогцолбор, 17 цэцэрлэгийн барилгад Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээ олгосон. | |
| 2.6. Үндэсний бахархал, өв соёл. Үндэсний үнэт зүйл, уламжлалт өв соёлоо дээдэлж, иргэдийг соён гэгээрүүлж, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэн, дэлхийн нүүдлийн соёл иргэншлийн төв болно. | | | | | | | | |
| 6. | 2.6.1.Үндэсний бахархал, монгол өв соёлыг өвлүүлж, олон улсын стандарт шаардлагад нийцсэн дараах барилга байгууламжийг барьж ашиглалтад оруулна. | 11 | Барилга байгууламжийг хүчитгэх эрх зүйн орчныг шинэчлэн сайжруулж, улсын хэмжээнд байгаа түүх соёлын дурсгалт барилга байгууламжийг үе шаттайгаар бэхэлж, хүчитгэх ажлыг эхлүүлнэ. | 2020-2024 | - | Эрх зүйн орчинг шинэчлэн сайжруулах санал боловсруулж шийдвэрлүүлнэ. | -"Түүх соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх замаар ашиглалтын хугацааг уртасгах туршилтын төсөл"-ийн нэгжид хүчитгэх, шинэчлэх шаардлагатай түүх соёлын дурсгалт 5 барилгын тайлан, дүгнэлтийг 2021 оны 05/324 дугаартай албан бичгээр хүргүүлэв. Үүнд:<br>- Улсын драмын эрдмийн театрын барилга,<br>- Монгол Улсын багшийн их сургуулийн анхны "А" байр,<br>- Нийслэлийн 1 дүгээр дунд сургуулийн барилга,<br>- Чойжин ламын сүм, музейн цогцолборын барилга,<br>- Богд хааны ордон музейн цогцолбор барилга.<br>Түүх, соёлын дурсгалт барилга байгууламжийг хүчитгэх журамд цахимаар санал хүргүүлэв. | 100 |
| ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО | | | | | | | | |
| *3.7.Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын нэгдмэл удирдлага, менежментийн тогтолцоог бэхжүүлж, иргэдийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ.* | | | | | | | | |
| 7. | 3.7.2."Цахим Монгол" арга хэмжээний хүрээнд олон улсын геодезийн сүлжээнд холбогдсон, байнгын ажиллагаатай станцуудаас бүрдсэн геодезийн хэмжил зүйн дэд бүтэц, хаягжилтын нэгдсэн системийг монгол орны нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд байгуулж, тэдгээрийн тоон мэдээллийг түгээх тогтолцоог үе шаттайгаар бий болгоно. | 1. | Улсын хэмжээнд хот суурингийн төвийн 1:1000-ны масштабтай байр зүйн зураг, газар доорх шугам сүлжээний зургийг солбицлын ITRF2020 эринд шилжүүлэх ажлыг зохион байгуулна. | 2023-2024 | - | - | Хэрэгжилт гаргах хугацаа болоогүй | - |
| | | 2. | Навигацын хиймэл дагуулаас мэдээ хүлээн авах суурин станц /GNSS/-ыг өргөжүүлэх замаар | 2022-2024 | - | - | Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын чиг үүрэгт хамаарал бүхий ажил тул биелэлт гаргах боломжгүй. Хасах саналтай. | - |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | байрлалын сүлжээний нарийвчлалыг 2 см хүртэл сайжруулж, геодезийн хэмжил, зураглалын үйл ажиллагаанд ашиглана. | | | | | |
| | | 3 | Батлан хамгаалах, газар зохион байгуулалт, хот байгуулалт, геологи хайгуул, байгаль орчин, авто зам,төмөр зам зэрэг салбарын эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн Монгол Улсын нутаг дэвсгэрийн 55 хувийг 1:25 000 масштабтай байр зүйн зургаар зурагжуулна. | 2020-2024 | - | - | Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын чиг үүрэгт хамаарал бүхий ажил тул биелэлт гаргах боломжгүй. Хасах саналтай. | - |
| | | 4 | Монгол Улсын өндрийн тулгуур сүлжээг шинэчилж өндрийн сүлжээний нарийвчлалыг сайжруулна. | 2020-2024 | - | - | Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын чиг үүрэгт хамаарал бүхий ажил тул биелэлт гаргах боломжгүй. Хасах саналтай. | - |
| | | 5 | Улсын хэмжээнд хаягийн мэдээллийн нэгдсэн системийг байгуулж, хэрэглээнд нэвтрүүлнэ. | 2020-2024 | - | Хаягийн мэдээллийн нэгдсэн системийг хэрэглээнд нэвтрүүлсэн байна. | НЗД-ын 2020 оны А/1048 дугаар "Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газраас Нийслэл, дүүргүүдийн хаягийн зургийг нийслэлд хүлээлгэн өгсөнтэй холбогдуулан уг хаягийн зураг, хаягийн мэдээллийн санг хянах, засварлах, зэрэгцүүлсэн хаягийн мэдээлэл үүсгэх" Ажлын хэсэг байгуулах тухай захирамж гарч доорх ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд:<br>✓ Геокад ХХК-ийн гүйцэтгэсэн нийслэлийн хаягийн зургийн гудамж, талбайн эхлэл, | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | төгсгөлийг шинэчлэх саналаа хүргүүлсэн.<br>✓ Хот байгуулалтын мэдээллийн санд бүртгэгдсэн барилга байгууламж, авто зам, гудамж талбайн нэршлийн шинэчлэгдсэн мэдээллийг ГЗБГЗЗГазар, Геокад ХХК-д тоон байдлаар хүргүүлсэн.<br>✓ ГЗБГЗЗГ, НХБХГ, НГЗБГ-ны удирдлагууд, холбогдох албан хаагчидтай хийсэн уулзалтаар Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас Засгийн газрын 2019 оны 325 дугаар тогтоолоор батлагдсан "Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журам"-д өөрчлөлт оруулж "Нийслэл, дүүргийн хаягийн зураг"-ийг шинэчлэх болсон тухай мэдэгдсэн тул Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1048 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн гүйцэтгэх ажил дууссан. | |
| | | 6 | Улсын хэмжээнд газар зүйн нэрийн тодруулалт хийнэ. | 2020-2024 | - | Газар зүйн нэрийн тодруулалт хийсэн байна. | Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын даргын 2019 оны А/211 дүгээр тушаалаар байгуулагдсан "Газар зүйн нэрийн зөвлөл"-д газрын төлөөлөл 5 удаагийн цахим хуралд оролцон саналаа өгсөн. Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/488 дугаар захирамжаар Нийслэл дэх "Газар зүйн нэрийн салбар зөвлөл" байгуулагдсан бөгөөд тус газрын төлөөлөл орон ажиллаж байна. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 8. | 3.7.3.Хиймэл оюун ухаан болон блокчейн, мэдээллийн аюулгүй байдал, нууцлалыг хангасан технологид суурилсан газар, үл хөдлөх хөрөнгийн нэгдсэн бүртгэл, үнэлгээ, төлбөр, татвар, биржийн системийг хөгжүүлж, үйл ажиллагааг эхлүүлнэ. | 3 | Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн суурь өгөгдлийг бүрдүүлэх, мэдээллийн нэгдсэн системийг бүрэн ашиглалтад оруулж, хэрэглээнд нэвтрүүлнэ. | 2022-2024 | - | - | Хэрэгжилт гаргах хугацаа болоогүй. | - |
| | | 5 | Байрлалд суурилсан орон зайн өгөгдөл, мэдээлэл, газрын биржийн удирдлагын нэгдсэн төв байгуулж, газрын харилцаатай холбоотой орон зайн өгөгдөл, мэдээллийн хүртээмжийг нээлттэй, ил тод болгоно. | 2020-2024 | - | - | Нийслэлийн Газар, зохион байгуулалтын албаны чиг үүрэгт хамааралтай ажил тул биелэлт гаргах боломжгүй. Хасах саналтай. | - |
| | | 7 | Улсын хэмжээнд ашиглагдаж буй барилга, байгууламжийн паспортжуулалт, тэдгээрийн чанар, насжилтыг тодорхойлж, цахим мэдээллийн нэгдсэн санд үнэлгээг оруулна. | 2021-2024 | 125.7 сая төгрөг | Барилга байгууламжийг паспортжуулах ажлыг аймаг нийслэлд үргэлжлүүлэн хийнэ. /200 барилга/ | 2011-2021 онд нийт 780 барилгад буюу 42.5 хувьд нь судалгаа хийн дүгнэлт гаргаж паспортжуулсан. Үүнд:<br>- Орон сууцны 617 барилга,<br>- Олон нийтийн 163 барилга<br>780 барилгыг паспортжуулах ажлын үр дүнгээс харахад:<br>- Газар хөдлөлтөд тэсвэртэй-188 барилга<br>- Бэхэлгээ хийж, хүчитгэх шаардлагатай-131,<br>- Газар хөдлөлтөд тэсвэргүй-461 барилга байна.<br>2021 оны байдлаар газар хөдлөлтөд тэсвэргүй 53 барилгыг буулгасан.<br>Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/378 дугаар захирамжаар барилга, байгууламжийн газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийн үнэлгээ | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хийж паспортжуулах 89 барилгын үйл ажиллагааны судалгааны зардалд 200,0 сая төгрөг батлагдаж, 186.4 сая төгрөгийн гэрээ байгуулсан боловч Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1179, 2021 оны А/189 дүгээр захирамжаар санхүүжих дүнд өөрчлөлт орж 60.7 сая төгрөгөөр хасагдаж 125,7 сая төгрөг батлагдсан. Батлагдсан төсвийн хүрээнд 89 барилгаас 73 барилгад биет, хэмжилт судалгаа хийж, 16 барилгад дүгнэлт гаргасан. | |
| 9. | 3.7.4 Хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурлан бүсчилсэн хөгжлийн бодлого, бүс нутгийн оновчтой бүтэц, хөгжлийн ирээдүйтэй суурины тодорхойлж, агаарын тээвэр, авто зам, төмөр замын сүлжээнд холбоно | 1 | "Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл"-ийг боловсруулж, батлуулан хэрэгжилтийг хангана. | 2020-2022 | - | "Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл"-ийг боловсруулна. | - Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл"-ийн судалгааны багтай 5 удаагийн уулзалт зохион байгуулж, уулзалтаас гарсан шийдвэрийн дагуу Улаанбаатар хотын хэмжээнд хийгдсэн хүн ам, нийгэм, эдийн засгийн төлөвлөлтийн тооцоо, таамаглалыг Барилгын хөгжлийн төвд хүргүүлж, тус газраас Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл боловсруулах ажлын хүрээнд хийгдсэн 2040 он хүртэл хэрэгжүүлэхээр төлөвлөж буй уул уурхай, зам тээвэр, үйлдвэр, эрчим хүчний мега төслүүдийн шууд болон шууд бусаар нэмэгдэж болох ажлын байр, түүнийг даган нэмэгдэх хүн амын тоо зэрэг хэтийн тооцоолoлтой холбоотой мэдээллийг авч ажлын уялдааг хангуулан ажиллаж байна.<br>- Барилга, хот байгуулалтын Сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч, Үндэсний хөгжлийн газрын даргын 2021 оны 171, А-65, А/625 дугаар хамтарсан тушаал, захирамжаар байгуулагдсан Монгол Улсын хэмжээнд хийгдэж байгаа Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл, Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө зэрэг хот байгуулалтын баримт бичгүүдийг боловсруулах ажлуудын хоорондын уялдааг хангах, нэгдсэн удирдлагаар зохион байгуулах чиг үүрэг бүхий | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ажлын хэсгийн хурал 2021 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр хуралдав. Хурлаас гарсан санал зөвлөмжийн дагуу холбогдох материалыг хүргүүлэн хамтран ажиллаж байна. | |
| | | 2 | "Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл"-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд бүсүүдийн хөгжлийн төслийг боловсруулна. | 2023-2024 | - | - | Улсын Их Хурлаар "Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл"-ийг баталсны дараа бүсүүдийн хөгжлийн төслийг боловсруулах тул хэрэгжилт гаргах хугацаа болоогүй. | - |
| | | 4 | Аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулна. | 2020-2024 | - | Улаанбаатар хотын газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулна. | - Нийслэлийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажилд "Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө 2040"-ын үзэл баримтлалтай холбоотой мэдээллийг 2021 оны 02/337 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Тус ажлын явцын тайлангийн хуралд 2021 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр оролцож, санал өгсөн. Тус ажлын гүйцэтгэлд Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба Захиалагчийн хяналт тавин ажиллаж байна.<br>- Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба, Нийслэлийн Хот Байгуулалт, Хөгжлийн газар, Хот Төлөвлөлт Судалгааны Институт ОНӨААТҮГ-ын дарга нарын хамтарсан 2021 оны А/625 А/53 А/37 дугаартай тушаалаар "Газар зохион байгуулалтын 2036 оны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө" болон "Улаанбаатар хотын 2040 оны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-г хооронд нь уялдуулах зорилготой ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсэг 2021 оны 09 дүгээр сарын 16-17-ны өдрүүдэд хуралдаж харилцан мэдээлэл солилцон ажлын хэсгийн гишүүдээс гарсан санал, зөвлөмжийг тусгуулсан.<br>- Нийслэлийн 2022 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгах саналаа 2021 оны 02/3128 дугаартай албан бичгээр | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд хүргүүлсэн. | |
| 10. | 3.7.5.Орхоны хөндийд шинэ хотын суурьшлын бүсийн байршлыг судалж, техник, эдийн засгийн үндэслэл боловсруулна. | 1 | Орхоны хөндийд шинэ хотын суурьшлын бүсийн байршлыг судлан сонгох, шинэ хот байгуулахад шаардлагатай техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулна. | 2020-2024 | - | - | “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 8.2.8./Орхоны хөндийд шинэ нийслэлийн байршлыг сонгож, техник, эдийн засгийн үндэслэл, хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлнэ/-т заасан тус ажлыг Барилга, хот байгуулалтын яам болон Үндэсний хөгжлийн газар хариуцан ажиллаж байгаа болно. | - |
| 11. | 3.7.6.Цахим эдийн засаг, үйлчилгээний салбарыг дэмжихэд шаардлагатай дэд бүтэц болох Улаанбаатар хотын дагуул хотыг барьж байгуулна. | 2 | “Шинэ Зуун мод”, “Майдар” хотуудын инженерийн хангамжийн шугам сүлжээг хонгилын систем, хагас нэвтрэх сувагт төлөвлөх, шинээр барьж байгуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | 2020-2024 | - | Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангана. | - “Шинэ Зуун мод”, “Майдар” хотуудын нутаг дэвсгэр нь засаг захиргааны нэгжийн хувьд Төв аймгийн Сэргэлэн суманд харьялагддаг тул тухайн хотуудын бүтээн байгуулалтын ажлыг Барилга, хот байгуулалтын яам хариуцан ажиллаж байна.<br>- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 390 дугаар тогтоолын дагуу Барилга, хот байгуулалтын яамны захиалгаар хийгдсэн “Майдар хот төсөл”-ийн Хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ болон түүнд зориулсан инженер-геологийн судалгааны тайлан, газрын төлөв байдал чанарын хянан баталгааны тайлан болон Байгаль орчин, аялал жуулчлалын яамны захиалгаар хийгдсэн “Майдар хот төсөл” хэрэгжих газрын ус хангамжийн эх үүсвэрийг тогтоох, газар доорх усны хайгуул, судалгаатай холбоотой мэдээллийг Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын гүйцэтгэгч “Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-т хүргүүлсэн. | - |
| 12. | 3.7.7.“Шинэ Зуунмод”, “Майдар” шинэ хотуудын хөгжлийн төлөвлөлтийг боловсруулж, бүтээн байгуулалтыг үе шаттайгаар хэрэгжүүлж эхэлнэ. | 1 | “Шинэ Зуунмод”, “Майдар” хотуудын засаг захиргааны нэгж, бүтэц, нутаг дэвсгэрийн хилийн цэсийг тогтоох | 2020-2024 | - | Холбогдох тооцоо судалгаа хийнэ. | *Шинэ зуун хот:* Засгийн газрын 2019 оны 29 дүгээр тогтоолоор Улаанбаатар хотын нисэх онгоцны шинэ буудлыг даган хөгжих Шинэ /Аэро сити/ хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тодотголыг боловсруулж баталсан. УИХ-ын 2020 оны 55 дугаар тогтоолоор Шинэ хот (Шинэ зуун мод хот) байгуулах шийдвэр гарсан. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | судалгаа хийж, шийдвэрлүүлнэ. | | | | Барилга, хот байгуулалтын сайдад Шинэ зуун мод хот /Аэросити/-ын хил хязгаарыг тогтоож, Нийслэлийн хилийн цэст өөрчлөлт оруулах саналыг Нийслэлийн Засаг даргын 2019 оны 01/3356 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 11.9-д "Ээлжит сонгуулийн жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш санал авах ажиллагаа дуустал засаг захиргаа, нутаг дэвсгэрийн анхан шатны нэгжийн бүтэц, нэр, дугаарт өөрчлөлт оруулахыг хориглоно" гэж заасны дагуу Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд "Шинэ Зуунмод", "Майдар" дагуул хотуудын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хилийн цэсийг өөрчлөх ажлыг 2022 оноос холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран зохион байгуулахаар тусгагдсан. Иймд тус ажлыг 2022 оноос эхэлж хэрэгжүүлнэ. Нийслэлийн хилийн цэс болон Төв аймгийн хилийн цэст өөрчлөлт оруулах асуудлыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал болон Төв аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын саналыг үндэслэн Улсын Их Хурал шийдвэрлэнэ. | |
| | | 2 | "Шинэ Зуунмод" хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг батлуулж, үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | 2020-2024 | - | Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулна. | - Улсын Их Хурлын 2020 оны 55 дугаар тогтоолоор Шинэ Зуунмод хотыг байгуулах шийдвэр гарсан бөгөөд "Шинэ Зуун мод" (Аэро сити) хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах зургийн даалгаврын төсөлд 2020 оны 02-03/1415 дугаартай албан бичгээр саналаа Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлсэн.<br>- Барилга, хот байгуулалтын яаманд хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын тайлантай танилцан саналаа 2021 оны 02/308 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажилд Барилга, хот байгуулалтын яам Захиалагчийн хяналт тавин ажиллана. | 50 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 3 | “Майдар” хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг батлуулж, үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | 2021-2024 | - | Хот байгуулалтын иж бүрэн үнэлгээг боловсруулсан байна. | “Майдар хот” төслийн хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ боловсруулах ажилд Барилга, хот байгуулалтын яам, усны эх үүсвэрийн судалгааны ажилд Байгаль орчин, аялал жуулчлалын яам захиалагчийн хяналт тавин ажиллаж байгаа бөгөөд тус ажлууд хийгдэж дууссаны дараа “Майдар” хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулагдана. Майдар хотын нутаг дэвсгэр нь засаг захиргааны нэгжийн хувьд Төв аймгийн Сэргэлэн суманд харьяалагддаг тул хот байгуулах үе шатны ажлын төлөвлөгөө, бүтээн байгуулалтын ажлыг Барилга, хот байгуулалтын яам хариуцан ажиллана. Улаанбаатар хотын 2040 оны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд Майдар хотын хөгжлийн ерөнхий концепц хүн амын бүтцийг тусган ажиллаж байна.<br>-“Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-ын 2021 оны 02/2850 дугаартай албан бичгээр Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 390 дүгээр тогтоолын дагуу хийгдсэн “Майдар хот төсөл” хэрэгжих газрын ус хангамжийн эх үүсвэрийг тогтоох, газар доорх усны хайгуул, судалгаатай холбоотой мэдээллийг хүргүүлсэн.<br>-Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд “Майдар” хотын хөгжлийн чиг хандлагыг бусад дагуул хаяа хот тосгодын төлөвлөлттэй уялдуулан боловсруулж байна. | 50 |
| 13. | 3.7.9.Хуримтлалын нэгдсэн санг байгуулан төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан 150 мянган өрх, айлыг орон сууцтай болоход дэмжлэг үзүүлж, орон сууцны хорооллыг барих ажлыг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд | 1 | Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хороонд "Ногоон нуур 1008 айлын орон сууц төсөл"-ийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна. | 2021-2024 | - | Төслийн хэрэгжилт 30 хувьд хүрнэ. | 2017 онд Сүхбаатар дүүргийн 9 хороо” Ногоон нуур 1008” айлын орон сууцны цогцолборын шав тавих нээлтийн ажиллагаа болсон. 2018 онд архитектур төлөвлөлтийн даалгавар, загвар зураг баталсан. Тус төслийг Барилга, хот байгуулалтын яам хариуцаж байна. | 100 |
| | | 2 | "Солонго 1", "Солонго 2" | 2020-2024 | - | Төсөл хэрэгжүүлэх | 2019 онд Хан-Уул дүүргийн 10 хороо “Буянт ухаа-2” хорооллын урд талд “Солонго 1” | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | тулгуурлан үе шаттай эхлүүлнэ. | | төслүүдийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна. | | | бэлтгэл ажлыг хангаж, төслийг эхлүүлнэ. | хорооллын Архитектур төлөвлөлтийн даалгавар, загвар зураг баталсан.<br>2020 онд Сонгинохайрхан дүүргийн 1 хороо, Баянголын аманд "Солонго 2" төслийн барилгын архитектур төлөвлөлтийн даалгавар, загвар зураг баталсан. | |
| | | 3 | "Баянголын амны орон сууц" барих төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна. | 2020-2024 | - | Төсөл хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангаж, төслийг эхлүүлнэ. | Сонгинохайрхан 22 дугаар хорооны нутаг дэвсгэрт "Баянголын амны орон сууц" хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу 4 га газарт орон сууцны хотхоны архитектур төлөвлөлтийн даалгавар батлагдсан. | 100 |
| | | 6 | Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх ажлын хүрээнд Улаанбаатар хотын гэр хорооллын 55 мянган өрхийг инженерийн дэд бүтцээр хангах төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 2020-2024 | - | БНХАУ-ын 700,0 сая юаны буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санал боловсруулан, холбогдох газарт хүргүүлнэ. | - Барилга, хот байгуулалтын яаманд Нийслэлийн 6 дүүргийн гэр хорооллын дахин төлөвлөлтийн 58 байршлын 32 багц төслийн гадна инженерийн шугам сүлжээний төлөвлөлтийн шийдэл, дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний ажлын зураг төсөл, барилга угсралтын ажилд шаардлагатай хөрөнгө оруулалтын тооцоог боловсруулан албан бичгээр хүргүүлсэн. Одоогоор хөрөнгө шийдвэрлэгдээгүй байна.<br>- Сонгинохайрхан дүүргийн 5, 6, 7-р хороо "Ханын материал" орчим нийт талбай 130 га, Сонгинохайрхан дүүргийн 10-р хороо "Арьс ширний ажилчдын байр" орчим нийт талбай 11.5 га талбайн гэр хорооллын дахин барилгажуулах ажлын даалгавар батлагдсан.<br>- Баянзүрх дүүргийн 12 дугаар хороо, 25.3 га нэгж талбарт хэрэгжиж буй "Бат хэрэйд" ХХК-ийн төслийн дэд бүтэц, гадна инженерийн шугам сүлжээний ажлын зураг төслийг зөвшилцсөн.<br>- Баянзүрх дүүргийн 13, 14 дүгээр хороо 11.6 га нэгж талбарт хэрэгжиж буй "Шинэ гэр түншлэл" ХХК, Сонгинохайрхан дүүргийн 23 дугаар хороо "Шинэ оргил" төслийн 24,0 га нэгж талбарын дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний төлөвлөлтийн шийдлийг хянасан. Гэр хорооллын дахин төлөвлөлтийг | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Нийслэлийн Орон сууцны дэд бүтцийн газар хариуцан ажиллаж байна. | |
| 14 | 3.7.12.Хот, суурины үерийн далан суваг, борооны болон хөрсний ус зайлуулах шугам сүлжээний ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | 1 | Улаанбаатар хотын үерийн хамгаалалтын далан, сувгийн өндөржилтийн нэгдсэн зураг төсөл боловсруулна. | 2020-2021 | - | Улаанбаатар хотын баруун, урд бүсийн өндөржилтийн нэгдсэн зураг төслийг боловсруулж батлуулсан байна. | Улаанбаатар хотын өндөржилтийн нэгдсэн төлөвлөлтийн зураг төсөл боловсруулах хөрөнгө шийдэгдэн, Улаанбаатар хотын суурьшлын хэсгийн нутаг дэвсгэр дэх Сонгинохайрхан дүүрэг 14454 га, Баянгол дүүрэг 2506 га / баруун бүс/, Хан-Уул дүүрэг 9150 га /урд бүс/ нийт 26110 га талбайд зураг төсөл боловсруулах ажлын даалгаврыг батлан Барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлэв. Тус ажилд "Инженер Геодези" ХХК Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр шалгаран гэрээ байгуулан ажиллаж байгаа бөгөөд дундын болон эцсийн тайланг Мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн хүлээн авсан. | 100 |
| | | 2 | Улаанбаатар хотын гадаргуугийн ба газар доорх үерийн хамгаалалтын барилга байгууламж төлөвлөх арга аргачлал, загварчлал хийх, инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөө боловсруулан батлуулна. | 2021-2022 | - | Улаанбаатар хотын гадаргуугийн ба газар доорх үерийн хамгаалалтын барилга байгууламж төлөвлөх арга аргачлал, загварчлал боловсруулж, мастер төлөвлөгөөг боловсруулах ажлыг эхлүүлнэ. | Улаанбаатар хотын гадаргуугийн ба газар доорх үерийн хамгаалалтын барилга байгууламж төлөвлөх арга аргачлал загварчлал, инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөөний ажлын зургийн даалгаврыг батлуулан Барилга, хот байгуулалтын яаманд албан бичгээр хүргүүлэв. Тус ажилд "Пристиж инженеринг" ХХК Зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр шалгаран гэрээ байгуулан ажиллаж байна. "Пристиж инженеринг" ХХК-аас ирсэн дундын тайланг хянан, санал хүргүүлэв.<br>Захиалагчийн хяналтыг Барилга, Хот байгуулалтын яам хариуцан гүйцэтгэж байна. | 70 |
| ***ТАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО*** | | | | | | | | |
| 5.1.Ногоон хөгжил. Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглаж, дэвшилтэт техник, технологи нэвтрүүлж, хүрээлэн буй орчны бохирдол, доройтлыг бууруулж, иргэдийн эрүүл орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ. | | | | | | | | |
| 15. | 5.1.1.Улаанбаатар хотын агаарын бохирдлыг 80 хувь хүртэл бууруулж, бусад томоохон хот, суурин газрын агаарын бохирдлын | 4 | Улаанбаатар хотын инженерийн шугам сүлжээг шинэчлэх, шинээр барих арга хэмжээг үе | 2020-2024 | - | Ус дулаан цахилгаан холбоо дохиоллын шугам | - Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/527 захирамжаар 2ф400/500мм-ийн голчтой 10,55 км дулаан хангамжийн төв магистраль шугамын хөрөнгө шийдвэрлэгдэн ажлын зураг төсөл боловсруулагдаж байна. Нийслэлийн Хөрөнгө | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэнэ. | | шаттайгаар хэрэгжүүлнэ. | | | сүлжээний зураг төслийг боловсруулж барилгын ажлыг эхлүүлнэ. | оруулалтын газар Зөвлөх үйлчилгээний захиалагчийн хяналтыг тавин ажиллаж байна.<br>- Улаанбаатар хотын хэмжээнд насжилт өндөртэй, ашиглалтын түвшин муудсан магистраль шугам сүлжээг шинэчлэх, өргөтгөх ажлыг үе шаттай гүйцэтгэх ажлын хүрээнд дараах өргөтгөл шинэчлэлийн ажлын зураг төсөл зөвшилцсөн.<br>Үүнд:<br>✓ Дулааны шугам 2.2 хос.км<br>✓ Цэвэр усны шугам 3.8 км<br>✓ Ариутгах татуургын шугам 1.2 км<br>- Улаанбаатар хотын Төвлөрсөн дулаан хангамжийн гол шугам сүлжээний ашиглалтын хугацаа дууссан санхүүжилт шийдвэрлэгдээгүй 10 байршилд нийт 2241 хос.км гадна дулааны өргөтгөл, шинэчлэлтийн ажлын зураг төсөл зөвшилцсөн.<br>- Европын сэргээн босголтын банкны санхүүжилтээр хийгдэх өргөтгөн шинэчлэх ажлын 2 байршилд нийт 3.7 хос.км, Дэлхийн банкны санхүүжилтээр хийгдэх 2 байршилд нийт 4.1 хос.км шугамын ажлын зураг төслийг зөвшилцөв.<br>- 2021-2023 онд Европын сэргээн босголт, хөгжлийн банкны санхүүжилтээр 2 чиглэлд 5.4 хос.км гол шугам хийгдэхээр төлөвлөгдсөний дагуу дулааны шугамын ажлын зураг төслийг урьдчилсан байдлаар зөвшилцсөн.<br>- Төр хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэж байгаа Ус хангамж , ариутгах татуургын шугам сүлжээний нийт 322 зураг төслийг хянан зөвшилцөв.<br>- Доод Өлзийтийн ам, Сонгино амралт, суурьшлын бүсийн Туул голын орчмын үерийн хамгаалалтын далангийн зураг төсөл, Төв цэвэрлэх байгууламжийн бохир ус Туулд голд нийлдэг хэсгийн эргийн хамгаалалтын далангийн зураг төсөл нийт 4 байршилд 18.6 км | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | үерийн хамгаалалтын сувгийн төлөвлөлтийн шийдэл зураг төслийг хянан зөвшилцөв.<br>- Хот байгуулалтын мэдээллийн санд инженерийн шугам сүлжээний 46989 метр трассыг оруулсан. Үүнд:<br>✓ Дулааны шугам 5196м<br>✓ Бохир усны шугам 11994м<br>✓ Инженерийн бэлтгэл арга хэмжээ 29799м | |
| ***ЗУРГАА. НИЙСЛЭЛ БА БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО*** | | | | | | | | |
| 6.1.Улаанбаатар болон дагуул хотыг орон зайн оновчтой төлөвлөлт, ухаалаг шийдэл, амьдралын таатай орчин бүхий ногоон хот болгож хөгжүүлнэ. | | | | | | | | |
| 16. | 6.1.1.Улаанбаатар хотын хөгжлийн төлөвлөгөөг "Алсын хараа-2050" урт хугацааны бодлогын баримт бичгийг үндэслэн 20 жилээр төлөвлөнө. | 1 | Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлнэ. | 2021-2024 | - | Хот байгуулалтын үндсэн суурь баримт бичигтэй болно. | Засгийн газрын 2020 оны 35 дугаар хуралдааны тэмдэглэлээр "Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үзэл баримтлал /концепц/"-ын дагуу холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн "Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-г боловсруулахыг Барилга хот байгуулалтын Сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч нарт даалгасан. Засгийн газраас өгсөн үүрэг даалгаврын дагуу Барилга, хот байгуулалтын Сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч хамтран "Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах ажлын даалгавар"-ыг боловсруулан Засгийн газрын 13 яам, Нийслэлийн 42 байгууллагуудаас санал авч, батлуулсан.<br>Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/860 дугаар захирамжийн дагуу "Хот төлөвлөлт, судалгааны институт" ОНӨААТҮГ 2020 оны 10 дугаар сарын 12-ний өдрөөс 2021 оны 11 дүгээр сарын 08-ны хооронд "Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-г боловсруулахаар зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулсан. Тус ажилд Захиалагчийн хяналт тавьж, Мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцэн эхлэл, дундын | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | тайлангийн гүйцэтгэлийг хянаж Мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн хүлээн авсан.<br>Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төсөлд 2021 оны 09 дүгээр сарын 29-ний өдрөөс 2021 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн хоорондох сарын хугацаанд иргэд, олон нийтээс https://ulaanbaatar2040.mn/ вэб хуудас, Улаанбаатар 2040 Facebook, twitter, Instagram, YouTube зэрэг олон нийтийн цахим сүлжээний хэрэгслүүд болон харьяа хороогоор дамжуулан санал авах үйл ажиллагааг "Хот төлөвлөлт, судалгааны институт" ОНӨААТҮГ-тай хамтран зохион байгуулсан. Санал асуулгад нийт 32,230 иргэн оролцож санал ирүүлснээс 12,907 иргэн цахимаар, 19,323 иргэн цаасаар өгсөн бол иргэдийн 91% нь хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийг дэмжсэн санал ирүүлсэн.<br>Хот байгуулалтын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1-д заасны дагуу "Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө", "Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө" боловсруулахад шаардлагатай хөрөнгийг Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны төсвийн хөрөнгө оруулалтад 300 сая, 2022 онд 338,3 сая төгрөг тусгагдсан.<br>Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний зураг төслийн баримт бичигт экспертиз хийх орон тооны бус экспертүүдийн Ажлын хэсгийн бүрэлдэхүүн Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 239 дүгээр тушаалаар томилогдон ажиллаж байгаа бөгөөд Монгол Улсын Засгийн газрын, Улсын Их Хуралд өргөн барьж батлуулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.<br>Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, шийдвэрийн төслийг | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | боловсруулж 2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн ээлжит бус IV хурлын IV-04/30 дугаар тогтоолоор "Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-ний төслийг Монгол Улсын Засгийн газар, Улсын Их Хуралд өргөн барих асуудал дэмжигдсэн. | |
| 17. | 6.1.2.Улаанбаатар хотын гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслүүдийг эрчимжүүлж, соёл, боловсрол, худалдаа үйлчилгээ, орон сууц, нийгмийн болон инженерийн дэд бүтцийн хангамж бүхий Баянхошуу, Сэлбэ, Дамбадаржаа, Дэнжийн 1000, Толгойт, Шархад, Дарь-Эх дэд төвүүдийг шинээр байгуулна. | 1 | "Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр" төслийн хүрээнд Баянхошуу, Сэлбэ, Дамбадаржаа, Дэнжийн 1000, Толгойт, Шар хад дэд төвүүдийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг үргэлжлүүлэн дуусгана. | 2021-2023 | - | - | Гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төслийн нэгж хариуцан ажиллаж байна. Хасах саналтай. | - |
| 18. | 6.1.3 Хотыг дахин хөгжүүлэх төслийн хүрээнд орон сууцны хангамжийг нэмэгдүүлж, гэр хорооллын газрыг шинэчлэн зохион байгуулж, ногоон орон сууц, шинэ суурьшлын бүсийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлнэ. | 2 | Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг шинэчлэн төлөвлөн барилгажуулах төслийг хэрэгжүүлнэ. | 2021-2025 | | 300 айлын орон сууц | - Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган дахин төлөвлөн барилгажуулах төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй урилгыг 2 удаа зарласнаар 20 барилгад төсөл хэрэгжүүлэгчээр шалгарсан аж ахуй нэгжүүдэд Нийслэлийн Засаг даргын захирамж, төсөл хэрэгжүүлэх батламжийг гардуулж газар, үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгч, эзэмшигчтэй гэрээ байгуулах эрх олгосон. 2021 онд 211 айлын 11 орон сууц буулгасан. Үүнд:<br>✓ БГД-ийн 4 дүгээр хорооны Давхрын 1, 2, 3, 4, 5 дугаар байр<br>✓ БГД-ийн 3 дугаар хорооны 22, 37 дугаар байр<br>✓ ХУД-ийн 2 дугаар хорооны Нэхмэлийн 12, 13, 17, 18 дугаар байр<br>Мөн 266 айлын 2 орон сууц ашиглалтад орсон. Үүнд: | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ✓ БГД-ийн 17 хорооны 27 дугаар байрны суурин дээр 140 айлын орон сууц<br>✓ ХУД-ийн 2 дугаар хорооны Нэхмэлийн 6 дугаар байрны суурин дээр 126 айлын орон сууц<br>Төсвийн хөрөнгөөр 10 барилга, хувийн хэвшлийн хөрөнгөөр 18 барилгыг буулган дахин барилгажуулахаар төлөвлөж байна. Төслийн хүрээнд 10 байршилд 28 хуучин орон сууцны барилгыг буулган шинээр төлөвлөн барилгажуулж 632 өрхийн 2212 хүн ам эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөл бүрдэнэ. | |
| 19. | 6.1.12.Богдхан төмөр замын төслийг түшиглэн "Хөгжлийн алтан тойрог" байгуулах техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулна. | 1 | Богдхан төмөр замын төслийг түшиглэн "Хөгжлийн алтан тойрог" байгуулах техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулна. | 2021-2024 | - | - | Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлагдсан "Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл", "Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т Улаанбаатар хот болон бусад дагуул, хаяа, хот, тосгодыг холбох Богд хан уулыг тойрсон нийтийн тээврийн сүлжээний "Хөгжлийн алтан тойрог" төслийн ТЭЗҮ-ийг 2022 оноос боловсруулахаар тусгуулсан. Хугацаа болоогүй. | - |
| 6.2.Бүс, орон нутаг, хөдөөгийн хөгжлийг дэмжиж, дэд бүтцийг хөгжүүлэн орон нутаг дахь иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлнэ. | | | | | | | | |
| 20 | 6.2.2.Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг шинэчлэн боловсруулж, эдийн засгийн төрөлжилт, дагналт, хоршилт бүхий ногоон үйлдвэрлэлийг хөгжүүлэх, бүс нутгийн эдийн засгийн интеграцид нэгдэх суурь нөхцөлийг бүрдүүлнэ. | 1 | Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг шинэчлэн боловсруулна. | 2021 | - | Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг шинэчлэн боловсруулж, Засгийн газарт өргөн барина. | - Монгол Улсын хэмжээнд хийгдэж байгаа Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл, Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлуудын хоорондын уялдааг хангах, нэгдсэн удирдлагаар зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулахаар Барилга, хот байгуулалтын сайд, Үндэсний хөгжлийн газрын дарга, Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн хамтарсан тушаал, захирамжийн төслийг бэлтгэн санал авахаар Үндэсний хөгжлийн газарт хүргүүлсэн.<br>- Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний эцсийн тайланд санал авах албан бичгийг Нийслэлийн Засаг даргын | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 2021 оны 01/4746 дугаартайгаар Үндэсний хөгжлийн газарт хүргүүлсэн.<br>- Барилга, хот байгуулалтын сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч, Үндэсний хөгжлийн газрын даргын 2021 оны 171, А-65, А/625 дугаар хамтарсан тушаал, захирамжаар байгуулагдсан Монгол Улсын хэмжээнд хийгдэж байгаа Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл, Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө зэрэг хот байгуулалтын баримт бичгүүдийг боловсруулах ажлуудын хоорондын уялдааг хангах, нэгдсэн удирдлагаар зохион байгуулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийн хурал хуралдаж, гурван бодлогын баримт бичгийн уялдааг хангуулах талаар хэлэлцсэн. | |

Тус газарт хамааралтай 20 зорилтын 36 арга хэмжээнээс , 20 зорилтын 23 арга хэмжээний хэрэгжилтийн хувь- 91.7 %

100 % тай хэрэгжүүлсэн ажил- 18
70 % тай хэрэгжүүлсэн ажил- 3
50 % тай хэрэгжүүлсэн ажил- 2

Хугацаа болоогүй -5
Хасах саналтай-8

ТАНИЛЦСАН:ЗАХИРГАА,САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Ч.БАДАМХАНД

НЭГТГЭСЭН: МЭРГЭЖИЛТЭН Н.ДҮНЖИЙМАА